



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 08 сарын 16 өдөр

Дугаар А/524

Ховд

Хөрөнгө гаргах тухай


Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын драмын эрдмийн театрын уран бүтээлчдэн тоглолт зохион байгуулсан зардалд 1,075,500 төгрөг, Өмнөд америкийн Эквадор улсын Qirwa Anka хамтлаг "Ховдын хүчтэнүүд" арга хэмжээд тоглуулсан зардалд 9,435,100 төгрөг, Урианхай, Тува, Дөрвөд угсаатны өв соёл, ёс уламжлал, зан заншил, язгуур урлагийг хойч үедээ өвлүүлэн үлдээх, түгээн дэлгэрүүлэх, сурталчлан таниулсан ахмадуудад хүндэтгэл үзүүлэх, зохион байгуулах зардалд 2 648 000 төгрөг, Захчин түмний өв соёлын Тонжоо наадмын зохион байгуулалтын зардалд 1 500 000 төгрөг, Хан Жаргалантын хурд 2022 Баруун бүсийн даншиг наадам зохион байгуулсан зардалд 7 637 900 төгрөгийг тус тус зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулах 22 296 500 төгрөг (Хорин хоёр сая хоёр зуу ерэн зургаан мянга таван зуун)-ийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн ангилагдаагүй зардлын нөөцөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхболд)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

8400 01 2708
Zah A/524 tum